

## МЕТАЛЛ – ФУЛЛЕРЕНЫ НИМГЭН ХАЛЬСНЫ ФИЗИК ЧАНАРТ ХЭМЖЭЭСИЙН ҮЗЭГДЛИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

*К.В. Доброго<sup>2\*\*</sup>, Ц.Хандмаа<sup>1\*</sup>, Э.М. Шипилевский<sup>2\*\*</sup>, М.Э.Шипилевский<sup>2\*\*</sup>, И.И. Васильев<sup>2\*\*</sup>,  
Г.Шилагарди<sup>1\*</sup>, Д.Томорбаатар<sup>1\*</sup>, Х.Цоохүү<sup>1\*</sup>, Д.Эрдэнэбаатар<sup>1\*</sup>, Р.Нямдулам<sup>1\*</sup>*

1. Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар

2. Институт тепло и массообмена имени А.В. Лыкова НАН Беларусь, Минск, Беларусь.

\*e-mail: handmaa\_04@yahoo.com

\*\*e-mail: eshpilevsky@rambler.ru

### АННОТАЦИЯ

Было показано, что тензочувствительности тонкой металлической пленки, допированной фуллеренами на один порядок выше чем исходной металлической пленки и по мере уменьшения толщины возрастает.

### ОРШИЛ

Диформацийн үзэгдэл бол биений шугаман хэмжээ, талбай, эзэлхүүн өөрчлөгдөхтэй холбоотой хэмжээсийн эффект юм. Иймээс тензорезисторын зузаан  $d$  түүний

тензомэдрэмж  $\gamma$  –д хүчтэй нөлөө үзүүлнэ. Доорх хүснэгтэд металлын нимгэн хальсны зузаан  $d$  түүний тензомэдрэмжид хэрхэн нөлөөлөхийг харууллаа.

#### 1-р хүснэгт

Тензомэдрэмжийн коэффициент, $\gamma$							
$d, \text{нм}$	400	200	100	50	20	10	5
Металл							
Cu	1.9	2.6	3.8	5.2	8.6	11.2	20
Au	1.8	2.2	3.0	5.4	9.0	10.5	22
Ti	1.4	2.0	3.1	5.2	8.5	9.1	12

Хүснэгтэд сийрүүлсэн үр дүнгээс үзвэл, металл нимгэн хальсны зузааныг 20 дахин багасгахад тензомэдрэмж бараг 10 дахин ихсэж байна. Тэтвэл металлыг бодвол тензомэдрэмж сайтай фуллеренээр чанаржсан металлын нимгэн хальсанд энэ эффект бүр хүчтэй ажиглагдах ёстой [1].

$l$  уртгай өргөн нь зузаан  $d$ -ээс н дахин их нимгэн хальсыг авч үзвэл түүний эсэргүүцэл

$$R = \rho \frac{l}{nd^2}, \quad R \sim \frac{l}{d^2}$$

Дээрх томъёоноос үзвэл дээжийн эсэргүүцэл зузаанаас хүчтэй хамаарах ажээ. Үнэхэр судалгааны үр дүнгээс үзвэл, металл – фуллерены нимгэн хальсны тензомэдрэмж түүний бүрэлдэхүүнд орж байгаа компонентуудын харьцаанаас хүчтэй хамаарна. Ялангуяа 100 нанометрээс бага зузаантай нимгэн хальсанд энэ үзэгдэл хүчтэй илэрч байв. Учир нь нимгэн хальсны зузаан багассанаас бүтцийн параметрууд өөрчлөгддөг. Кристаллын

### ТУРШЛАГЫН ҮР ДҮН БА ТҮҮНИЙГ ШҮҮН ТҮНГААХ

Фуллеренээр чанаржуулсан зэс, алт, титаны нимгэн хальсыг вакумд ууршуулах аргаар гарган авч тэдгээрийн эсэргүүцлийн харьцангуй өөрчлөлтийг хэмжлээ [3]. Хэрэв

мөхлөгүүд доторх дотоод механик хүчлэг гадаргуугийн морфологи, фуллеридын талдаа ба эзлхүүндээ төвтэй үенүүдийн байрлал өөрчлөгддөг байна.

2-р хүснэгтэд бидний судалсан нимгэн хальсны металлын атом ба фуллерены

молекулын тооны харьцаа  $N_{\text{met}}/N_{C60}$ , нимгэн хальсны зузаан  $d$ , эсэргүүцэл  $R$ , хувийн эсэргүүцэл  $\rho$ , тензомэдрэмж  $\gamma$ -г сийрүүлэн бичлээ.

### 2-р хүснэгт

Me	$N_{\text{me}}/N_{C60}$	$d$ , нм	$R$ , Ом	$\rho$ , Ом $\cdot$ см	$\gamma$
Cu	50	100	30,6	0,18	15
	80	100	5,95	0,035	9,8
	300	50	2,04	0,024	7,9
	700	50	0,88	0,010	6,8
Au	30	100	35,7	0,21	40
	60	100	20,4	0,12	21
	120	50	12,1	0,14	18
	200	50	6,12	0,072	16
Ti	50	100	68	0,4	24
	80	100	19,9	0,082	16
	300	50	3,74	0,044	11
	700	50	2,55	0,030	9,6

2-р хүснэгтэд үзүүлсэн судалгааны үр дүнгээс үзвэл, фуллеренээр чанаржуулсан зэс, алт, титаны нимгэн хальсны зузаан багасах тусам тэдгээрийн тензомэдрэмж  $\gamma$  ихсэх боловч материаллын доторх фуллерены молекулын хувь ихсэхэд тензомэдрэмж нь улам сайжирч байна. Иймээс практикт нимгэн хальсны зузаан, металлын атом ба фуллерены молекулын тооны зохижтой харьцаа, нимгэн хальсны бат бэх

чанарыг үйлдвэрлэл явуулах технологийн горимтой уялдуулсан оптимал зузааныг сонгон авах хэрэгтэй ажээ [2]. Эцэст металлын нимгэн хальстай адилхан зузаантай металлын атом ба фуллерены молекулын тоон харьцаа  $N_{\text{met}}/N_{C60}=80$ -тай тэнцүү металл-фуллерены нимгэн хальсны тензомэдрэмж  $\gamma$  зузаанаас хэрхэн хамаарахыг харуулсан туршлагын үр дүнг 3-р хүснэгтэд сийрүүлэн бичлээ.

Тензомэдрэмжийн коэффициент, $\gamma$							
$d, \text{ нм}$ $N_{\text{Me}}/N_{C_60}$	400	200	100	50	20	10	5
Cu – C <sub>60</sub>	3.4	5.6	8.8	12	56	94	120
Au – C <sub>60</sub>	3.2	5.2	8.0	24	60	95	122
Ti – C <sub>60</sub>	2.9	5.1	8.1	22	55	91	112

1 ба 3-р хүснэгтэд бичигдсэн цэвэр металл ба фуллеренээр чанаржуулсан нимгэн хальсны ( $N_{\text{met}}/N_{C_60}$ ) тензомэдрэмж  $\gamma$ -г харьцуулан үзвэл, фуллерен агуулсан нимгэн хальснаас бараг нэг эрэмбээр их байна. Иймээс метал-фуллерены нимгэн хальсаар үйлдсэн тензорезистрыг сенсорын идэвхитэй элемент болгон ашиглах нь хэт ирээдүйтэй ажээ [3].

## ДҮГНЭЛТ

1. Металл фуллерены нимгэн хальсны хэмжээсийн эфектийг судалсан үр дүнгээс үзвэл, метал-фуллерены нимгэн хальсны тензомэдрэмж  $\gamma$ , цэвэр металлынхаас бараг нэг эрэмбээр их байна. Гэтэл цагаан алтны  $\gamma=1.6$ -ээс хэтрэдэгүй.
2. Металл нимгэн хальсны зузааныг багасгасаар байгаад түүний тензомэдрэмж  $\gamma$ -г 100-120 хүргэж болно.

## НОМ ЗҮЙ

1.П.А.Витязь, Э.М.Шпилевский,  
М.Э.Шпилевский“Фуллеренсодержащие  
материалы и функциональные элементы на их  
основе” Нанотехнологии: наука и производство.  
2009, №2, Стр 12-16

2.E.M.Shpilevsky, M.E.Shpilevsky,  
Y.I.Prylutsky, L.Y.Matzuy,M.I.Zakharenko,  
F.Le.Normand “Structure and properties of C<sub>60</sub>  
fullerene films With titanium atoms.Mat.-  
wiss.u.Werkstofftech. 2011. Vol.42 №1 PP.59-63

3. Э.М.Шпилевский, “Металл-  
фуллереновые плёнки:получение свойства ,  
применение” Алмазные плёнки и плёнки  
родственных материалов.-Харьков :ХНЦ ФТИ ,  
2003-С,242-264